

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ  
ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ  
НАРЫН ХАМТАРСАН ТУШААЛ, ЗАХИРАМЖ

2019 оны 05 дугаар  
сарын 23-ны өдөр

Дугаар А/494

Улаанбаатар  
хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэгт тус тус заасныг үндэслэн ТУШААХ/ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улаанбаатар хотын гудамж, талбайг камерын хяналтын нэгдсэн системд холбох, камерын хяналтын нэгдсэн төв байгуулах талаар санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Г.Элбэгсайхан

-Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд

Ажлын хэсгийн дэд ахлагч:

М.Халиунбат

-Нийслэлийн инновац, технологийн асуудал хариуцсан төслүүдийн удирдагч

Гишүүд:

Э.Энхтуяа

-Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга

Ц.Цэвэлмаа

-Хууль зүй, дотоод хэргийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга

Д.Соёлмаа

-Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын газрын мэргэжилтэн

М.Мэнд-Очир

-Нийслэлийн Засаг даргын зөвлөх

Д.Ядамдорж

-Цагдаагийн ерөнхий газрын Дэд бөгөөд Нийслэлийн цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа

О.Зоригт

-Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны дарга, цагдаагийн хурандаа

О.Чинзориг

-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Мэдээлэл, технологийн газрын дарга

Д.Одбаяр

-“Замын хөдөлгөөний удирдлагын төв” Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын дарга

Б.Чинзориг

-Цагдаагийн ерөнхий газрын Онцгой нөхцөл байдал, шуурхай удирдлага зохицуулалтын хэлтсийн хамгаалалт, төлөвлөлт хариуцсан чиглэлийн ахлах офицер, цагдаагийн ахмад

С.Батнасан

-Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын Мэдээллийн технологийн Бодлого зохицуулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга:

Ч.Одонбаяр

-Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн

2. Улаанбаатар хотын гудамж, талбайг камерын хяналтын нэгдсэн системд холбох, камерын хяналтын нэгдсэн төв байгуулах талаар санал боловсруулж 2019 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор танилцуулахыг Ажлын хэсгийн ахлагч /Г.Элбэгсайхан/-д даалгасугай.

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД  
ХЭРГИЙН САЙД

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД  
УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ

Ц.НЯМДОРЖ

С.АМАРСАЙХАН